

2015 оны 08 сарын 28 өдөр

№ 2015/10.

Улаанбаатар хот

## Гишүүний эрх цуцалж, гишүүнээс хасах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дах заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 212, 280, 283, 332 дугаар тогтоолууд, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.1, 7.3.17, Гишүүнчлэлийн журмын 8 дугаар зүйлийн 8.1.5.2 дах заалтууд, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын 5 дугаар зүйлийн 5.4-д заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс ирүүлсэн санал зэргийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “АБЖЯ” ХХК, “Глобал-Ассет ҮЦК” ХХК, “Түшигтраст” ХХК, “Юнайтэд секьюритс ҮЦК” ХХК тус бүрийн Монголын хөрөнгийн биржийн гишүүний эрхийг цуцалж, биржийн гишүүнээс хассугай.
2. Тогтоолын нэгдүгээрт заасан компаниудын биржтэй холбогдох авлага, өглөгийг барагдуулахыг Санхүү төлөвлөлтийн алба /Н.Уянга/-д, цаашид үнэт цаасны компаниудын брокер, дилерийн эрхийг нь цуцлах тухай Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр гарахаас өмнө тухайн компанитай авлага, өглөгийн тооцоог дуусгаж байх эрх зүйн боломж бололцооны талаар судалж, танилцуулахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Ангар/-д тус тус даалгасугай.
3. Дээрх компаниудын биржийн гишүүний эрхийг цуцалсан тухай мэдээллийг олон нийтэд мэдээлж, холбогдох мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК тус бүрт хүргүүлэх, энэхүү тогтоолын биелэлтийг хангаж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Ангар/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.НЯМАА